

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 12-ны 187 тоот
тушаалын 15 дугаар хавсралт*



ИНД - 146

Иргэний Нисэхийн Дүрэм

**Агаарын хөлөг зохион бүтээх байгууллагын
гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-146 нь агаарын хөлөг зохион бүтээх байгууллагын гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагааны болон загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн эрх шилжүүлэх зохицуулалтын шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-146-гийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-146, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх

Анхны боловсруулалт

Хүчинтэй огноо

2019 оны 06 сарын 12

Тэмдэглэл: ИНД-146-гийн анхны боловсруулалтыг монгол, англи хэл дээр, NZ Part 146-гийн 2017 оны 03 сарын 10-ны А.4-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	1
146.1. Зорилго	1
146.3. Нэр томъёо ба товчлол	1
146.5. Гэрчилгээний шаардлага	1
146.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах.....	1
146.9. Гэрчилгээ олгох	1
146.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	2
146.13. Гэрчилгээний хугацаа	2
146.15. Зохион бүтээх ажиллагааг зогсоох мэдэгдэл	2
146.17. Гэрчилгээ сунгах.....	2
В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	3
146.51. Ажилтанд тавих шаардлага.....	3
146.53. Байгууламжийн шаардлага	3
146.55. Төхөөрөмж, багаж хэрэгсэл болон өгөгдөл	4
146.57. Зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцоо	4
146.59. Зохион бүтээх ажиллагааны хяналтын журам	4
146.61. Нислэгт тэнцэх чадварын хадгалалт	5
146.63. Бүртгэл хөтлөх.....	6
146.65. Аюулгүй байдлын удирдлага.....	6
146.67. Зохион бүтээх байгууллагын Ерөнхий заавар.....	7
С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага	8
146.101. Байнгын хэрэгжилт	8
146.103. Загварын үргэлжлэл.....	8
146.105. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт	8
Д Бүлэг - Шилжилтийн зохицуулалт	9
146.151. Зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилт	9
146.153. Зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт	10
Хавсралт А - Загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн эрх шилжүүлэх	13
А.1. Эрх, хязгаарлалт	13
А.2. Мэргэшил	13

А Бүлэг - Ерөнхий зүйл

146.1. Зорилго

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) агаарын хөлөг зохион бүтээх байгууллагын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагаа;
- (2) загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн эрх шилжүүлэх.

146.3. Нэр томьёо ба товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

146.5. Гэрчилгээний шаардлага

Аливаа этгээд энэ дүрмийн дагуу олгосон агаарын хөлөг Зохион бүтээх байгууллагын (ЗББ) гэрчилгээний нөхцөл болон эрхийн хүрээнээс гадуур 146.11-д заасан эрхийг эдлэхгүй.

146.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(а) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24146/01 маягтыг бөглөх үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагчийн нэр болон Монгол Улсад үйлчилгээ үзүүлэх хаяг;
- (2) хүсэлт гаргагчтай холбоотой Даргын шаардаж болох, маягтад заасан нэмэлт мэдээлэл.

(b) Хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА 24146/01 маягтыг зохих төлбөрийн баримтын хамт Даргад ирүүлэх үүрэгтэй.

146.9. Гэрчилгээ олгох

Хэрэв Дарга хүсэлт гаргагчийг дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, ЗББ-ын гэрчилгээг Хууль болон энэ дүрмийн дагуу олгох үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагч нь В Бүлгийн шаардлагыг хангасан;
- (2) хүсэлт гаргагч болон 146.51(а)-ийн дагуу шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

146.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(a) ЗББ-ын гэрчилгээнд, тухайн гэрчилгээгээр олгосон, байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан дараах 1, эсхүл хэд хэдэн зохион бүтээх зэрэглэлийг заана:

- (1) D1 - бүтээгдэхүүн, түүний бүрдэл хэсгийн загварыг зохиож, боловсруулах;
- (2) D2 - бүтээгдэхүүн, түүний бүрдэл хэсгийн загварын өөрчлөлтийг зохиож, боловсруулах;
- (3) D3 - хэрэгслийн загвар болон түүний загварын өөрчлөлтийг зохиож, боловсруулах.

(b) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд заасан зохион бүтээх зэрэглэлээр зөвшөөрсөн загварыг зохиож, боловсруулж болно.

(c) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь 146.51(a)(3)-ын дагуу загварын өөрчлөлтийг баталгаажуулах этгээдийг ажиллуулж болно.

(d) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь ИНД-21-ийн В Бүлгийн дагуу маягийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.

146.13. Гэрчилгээний хугацаа

(a) ЗББ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.

(b) ЗББ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.

(c) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болгосон бол гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.

(d) ЗББ-ын гэрчилгээг түдгэлзүүлсэн бол эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

146.15. Зохион бүтээх ажиллагааг зогсоох мэдэгдэл

(a) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохион бүтээх үйлчилгээг санал болгохоо зогсоосон өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ.

(b) Тухайн мэдэгдэлд ЗББ-ын гэрчилгээг хүчингүй болгох тухай хүсэлтийг хавсаргана.

146.17 Гэрчилгээ сунгах

(a) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24146/01 маягтаар гаргана.

(b) Тухайн хүсэлтийг, гэрчилгээнд заасан сунгах хугацаанд, хэрэв гэрчилгээнд сунгах хугацаа заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.

В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

146.51. Ажилтанд тавих шаардлага

(a) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын бүх ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй, Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан;
- (2) тухайн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд. Удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь дараах үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх үүрэгтэй:
 - (i) зохион бүтээх ажиллагааны хяналт;
 - (ii) үзлэг шалгалт болон тест;
 - (iii) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (3) хэрэв тухайн байгууллагад загварын зөвшөөрөл олгох ажиллагаа шаардлагатай бол ИНД-21.73-ын дагуу загварын өөрчлөлтийг зөвшөөрөх шилжүүлсэн эрх эзэмшдэг удирдах ажилтан;
- (4) Ерөнхий зааварт заасан зохион бүтээх ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

(aa) Энэ зүйлийн (a)(2)(iii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагаатай холбоотой туршлага, ур чадвараа харуулах үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа зохион бүтээх ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, эсхүл гэрчилгээжүүлэх ажилтны ур чадварт суурь үнэлгээ хийх ба түүнийг хадгалах журмыг тогтоох;
- (2) тухайн ажилтанд, түүний эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.

146.53. Байгууламжийн шаардлага

(a) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх зохион бүтээх үйл ажиллагаанд тохирсон байгууламжтай байна.

(b) Хүсэлт гаргагч нь дараах байгууламжтай байна:

- (1) өөрийн зохион бүтээх үйл ажиллагааг удирдах захиргааны байр;
- (2) төхөөрөмж, багаж хэрэгсэл болон загварын өгөгдлийг хадгалах, хадгалагдаж байгаа эд зүйл гэмтэх, элэгдэхээс сэргийлэх хяналттай агуулах.

(c) Хүсэлт гаргагч нь түүний бүрдүүлсэн орчин нь гүйцэтгэх ажилд, ялангуяа тест хийх холбогдох тодорхойлолтод заасан тусгай шаардлагад нийцсэн болохыг бататгана.

146.55. Төхөөрөмж, багаж хэрэгсэл болон өгөгдөл

ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх зохион бүтээх ажиллагаанд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл болон загварын тогтоосон өгөгдлийг ашиглахад боломжтой байлгана;
- (2) дараах ажиллагааг багтаасан, төхөөрөмж, багаж хэрэгсэл болон загварын тогтоосон өгөгдлийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандарт болон давтамжаар хянах журмыг тогтооно:
 - (i) багаж хэрэгсэл, тестийн төхөөрөмжийн тохируулга хийх;
 - (ii) загварын тогтоосон өгөгдлийг баталгаажуулах.

146.57. Зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцоо

ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах, зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлнэ:

- (1) тухайн байгууллагын ашигладаг загварын тогтоосон өгөгдөл нь, зохион бүтээх ажиллагаа бүрд тохирч байгааг тодорхой давтамж болон стандартаар баталгаажуулдаг болохыг;
- (2) тухайн байгууллагын нэрийн өмнөөс туслан гэрээлэгчийн гүйцэтгэх зохион бүтээх ажиллагаа нь:
 - (i) байгууллагын Ерөнхий зааварт тодорхойлогдсоныг;
 - (ii) байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан тогтолцоо, журам болон тодорхойлолтыг хангасныг;
- (3) хүсэлт гаргагчийн нийцлийн мэдэгдлийн хамт гаргах загвар, эсхүл загварын өөрчлөлт нь хамааралтай НТЧ-ын загварын стандартыг хангаж байгаа болон аюултай хэв шинжгүй болохыг;
- (4) ИНД-146.51(а)(3)-т шаардсан, хүсэлт гаргагчийн удирдах ажилтны баталгаажуулах загварын өөрчлөлт нь хамааралтай НТЧ-ын шаардлагыг хангаж байгаа, аюултай хэв шинжгүй ба хэрэгжүүлэлтэд тохирохыг.

146.59. Зохион бүтээх ажиллагааны хяналтын журам

(а) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, түүний Ерөнхий зааварт заасан зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион бүтээх ажиллагааны хяналтын заавар, барилга байгууламжийн заавар, НТЧ-ын загварын стандарт, тодорхойлолт, техникийн стандарт болон практик ажиллагааны заавар, иш татсан материал, холбогдох бусад баримт бичгийн хувийг хадгалах үүрэгтэй.

(b) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтооно:

- (1) ашиглах техникийн зургийн системийг хянах;
- (2) техникийн зураг зурах, шалгах болон хяналт тавих;
- (3) маягийн загварын үлгэр хийц гаргаж, НТЧ-ын загварын стандартыг хангаж байгааг үзүүлэх тест болон үзлэг шалгалт хийх;

- (4) ачааллын дүн шинжилгээ болон шалгах нислэгийн тайланг багтаасан НТЧ-ын загварын стандартыг хангаж байгааг үзүүлэх тайлан гаргах, шалгах болон хянах;
- (5) нийцлийн мэдэгдэл гаргах, тухайн мэдэгдэлд гарын үсэг зурах эрх бүхий ажилтны жагсаалт хөтлөх;
- (6) загварын өөрчлөлтийн зөвшөөрөл олгох, тухайн зөвшөөрөлд гарын үсэг зурах эрх бүхий, 146.51(а)(3)-т шаардсан удирдах ажилтны жагсаалт хөтлөх;
- (7) 146.51(а)(3)-т шаардсан удирдах ажилтан нь дараах нөхцөлийг бататгах:
 - (i) Хавсралт А-ийн шаардлагыг хангаж байгааг;
 - (ii) загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн хувийг, зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 28 хоногийн дотор ИНЕГ-т хүргүүлдэг болохыг;
- (8) дараах шаардлагыг бататгах зорилгоор, энэ зүйлийн (а)-д шаардсан баримт бичгийг хянах:
 - (i) баримт бичгийг гаргахын өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг болохыг;
 - (ii) Ерөнхий зааварт заасан зохион бүтээх ажиллагааг хэрэгжүүлэхдээ ажилтан ашиглахад боломжтой байх зорилгоор, холбогдох хүчинтэй баримт бичгийг шаардлагатай байрлал бүрд бэлэн байлгахыг;
 - (iii) хүчингүй болсон баримт бичгийг олгох цэгээс, эсхүл ашиглаж байгаа бүх цэгээс нэн даруй хураадаг болохыг;
 - (iv) баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг болохыг;
 - (v) зөвхөн тухайн загвартай холбоотой баримт бичгийг ашиглаж байгааг бататгах зорилгоор баримт бичгийн зүйл бүрийн хүчинтэй хувилбарыг таних боломжтойг;
- (9) Даргын хүсэлтээр маягийн гэрчилгээ, загварын мэдээлэл, техникийн зураг, төстийн тайлан болон үзлэг шалгалт хийсэн бүртгэлийг Даргад хүргүүлэх.

146.61. Нислэгт тэнцэх чадварын хадгалалт

- (a) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтооно:
 - (1) хүсэлт гаргагчийн бүтээсэн загварын гэмтэлтэй холбоотой мэдээллийг цуглуулах, шинжлэн шалгах болон дүн шинжилгээ хийх, тухайн мэдээллийг дараах этгээдэд түгээх:
 - (i) тухайн загварын бүтээгдэхүүн, бүрдэл хэсэг, эсхүл хэрэгсэл үйлдвэрлэгч бүрд;
 - (ii) ЗББ-аас тухайн загварыг хүлээн авсан этгээд бүрд;
 - (2) гэмтлийн зөрчлийн мэдээллийг ИНД-12-т заасны дагуу ИНЕГ-т хүргүүлэх.
- (b) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тэдний зохион бүтээсэн, маягийн гэрчилгээтэй бүтээгдэхүүнд хамааралтай дараах журмыг тогтооно:

- (1) тухайн бүтээгдэхүүний худалдан авагч бүрийг, бүтээгдэхүүнийг нийлүүлэх үеийн, эсхүл тухайн агаарын хөлгийн эхний стандарт ангиллын НТЧ-ын гэрчилгээ олгох үеийн аль сүүлд болох хугацаанд хамаарах, ИНД-21-ийн Хавсралт С-д заасан хамааралтай НТЧ-ын загварын стандартын дагуу бэлтгэсэн НТЧ-ын хадгалалтын зааварчилгааны нэгээс доошгүй иж бүрдлээр хангах;
- (2) эдгээр зааварчилгааг мөрдөхийг ИНД-ээр шаардсан бусад этгээд тухайн зааварчилгаа болон зааварчилгааны өөрчлөлтийг ашиглахад бэлэн байлгах;
- (3) энэ зүйлийн (а)-д шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээллийг ижил маягийн бүтээгдэхүүнийг өмчлөгч бүрд мэдээлэх.

146.63. Бүртгэл хөтлөх

(а) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн загвар, загварын өөрчлөлт нь холбогдох загварын өгөгдөлтэй тохирч байгааг бататгахад шаардлагатай бүртгэлийг ангилах, бүрдүүлэх, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журмыг тогтооно.

(b) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтооно:

- (1) эзэмшигчийн нэрийн өмнөөс гэрчилгээжүүлэлтийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээдийн туршлага, мэргэшил, сургалт болон эзэмшиж байгаа хүчинтэй эрхийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх;
- (2) эзэмшигчийн зохион бүтээсэн бүх загвар, загварын өөрчлөлтийн бүртгэл хөтлөх;
- (3) тухайн загвар, загварын өөрчлөлт нь хамааралтай НТЧ-ын загварын стандартад тохирч байгааг харуулах бүх техникийн зураг, туршилт, дүн шинжилгээ болон тайланг хадгалах;
- (4) загварын тогтоосон өгөгдлийн баталгаажуулалтын огноо болон баталсан этгээдийн бүртгэл хөтлөх;
- (5) 146.55-д заасан багаж хэрэгсэл, төхөөрөмжийн тохируулгын болон тохируулга хийхэд ашигласан стандартын бүртгэл хөтлөх;
- (6) дараах шаардлагыг бататгах:
 - (i) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын, арилдаггүй байдалтай болохыг;
 - (ii) энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, (b)(1) - (b)(5)-д заасан бүртгэлийг тухайн бүтээгдэхүүний маягийн сүүлчийн хувилбар ашиглалтаас бүрмөсөн хасагдсанаас хойш 2 жил хадгалдаг болохыг.

(с) Дарга бүртгэлийг энэ зүйлийн (b)(6)(ii)-т шаардсанаас богино хугацаагаар хадгалахыг зөвшөөрч болно.

146.65. Аюулгүй байдлын удирдлага

ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй.

146.67. Зохион бүтээх байгууллагын Ерөнхий заавар

(a) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журамд дараах шаардлагыг багтаасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) тухайн ЗББ-ыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;
 - (ii) түүнийг байнга дагаж мөрдөх;
- (1A) 146.65-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) ЗББ-ын гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 146.51(a)(1), (2) болон (3)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэр;
- (3) 146.51(a)(1), (2) болон (3)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
 - (i) байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын хариуцлага;
- (4) 146.51(a)(1), (2) болон (3)-т заасан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (4A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (5) хүсэлт гаргагчийн зохион бүтээх ажиллагаа болон тест хийх бүх байрлал, тэдгээр байрлалд байгаа байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (6) энэ зүйлийн (a)(5)-д заасан байрлал бүрд, шаардлага хангасан орчин нөхцөлийг бүрдүүлсэн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) энэ зүйлийн (a)(5)-д заасан байрлал бүрд байгаа хүсэлт гаргагчийн ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (8) хүсэлт гаргагчийн гүйцэтгэх ажлын цар хүрээний дэлгэрэнгүй тодорхойлолт;
- (9) хүсэлт гаргагчийн зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцооны дэлгэрэнгүй тодорхойлолт;
- (10) тухайн байгууллагаас бусад этгээдэд олгосон зохион бүтээх ажлын болон тест хийх зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (11) дараах дүрмээр шаардсан байгууллагын журмын дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) 146.51(b) - ажилтны ур чадварын талаар;
 - (ii) 146.51(b) - ажилтны байнгын сургалтын талаар;
 - (iii) 146.55(2) - багаж, тестийн төхөөрөмжийн хяналт, тохируулгын талаар;
 - (iv) 146.55(2) - загварын өгөгдлийн баталгаажуулалтын талаар;
 - (v) 146.59(b) - зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцооны үйл ажиллагааны талаар;

- (vi) 146.61(a) - хэрэг явдал болон гэмтэлтэй холбоотой мэдээллийг цуглуулах, шинжлэн шалгах, дүн шинжилгээ хийх болон түгээх талаар;
 - (vii) 146.61(b) - тухайн байгууллагын зохион бүтээж, маягийн гэрчилгээ олгосон бүтээгдэхүүний НТЧ-ын хадгалалтын зааварчилгааны талаар;
 - (viii) 146.63(a) - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах талаар;
 - (ix) 146.63(b) - бүртгэлийн агуулга болон хадгалалтын талаар;
- (12) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

146.101. Байнгын хэрэгжилт

ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын хүчинтэй нэгээс доошгүй бүрэн хувийг Ерөнхий зааварт заасан ажлын байрлал бүрд хадгална;
- (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог дагаж мөрдөнө;
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлэг бүрийг ажилтан үүргээ гүйцэтгэхэд хэрэглэх боломжтой байлгана;
- (4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэхэд тавих В Бүлгийн шаардлагыг хэрэгжүүлэн, стандартыг байнга дагаж мөрдөнө;
- (5) зөвшөөрөгдсөн, эсхүл зөвшөөрөл авахаар хүргүүлсэн загвар, эсхүл загварын өөрчлөлт нь хамааралтай НТЧ-ын шаардлага хангаж байгаа, аюултай хэв шинжгүй болон хэрэгжүүлэлтэд тохирохыг тодорхойлно.

146.103. Загварын үргэлжлэл

Хамааралгүй

146.105. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

- (a) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг байгууллагын хүчинтэй тодорхойлолт хэвээр хадгалагдаж байхаар хийсэн болохыг бататгах үүрэгтэй.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:
 - (1) Ерөнхий зааварт хийсэн нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаж байгааг бататгах;
 - (2) Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрддөг болохыг бататгах.
- (c) Энэ зүйлийн (d)-г харгалзан, гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан даруйд нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхээс өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

- (1) Гүйцэтгэх захирал;
- (2) нэр заагдсан удирдах ажилтнууд;
- (3) гэрчилгээ эзэмшигчийн зохион бүтээх ажиллагааны цар хүрээ;
- (4) үйл ажиллагаа гүйцэтгэх байрлал;
- (5) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол.

(e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг Дарга тогтоож болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь ЗББ-ын гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.

(h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.

D Бүлэг - Шилжилтийн зохицуулалт

146.151. Зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилт

(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:

- (1) ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч;
- (2) ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.

(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөхгүй байж болно:

- (1) 146.51(a)(2)(iii)-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 146.65-ыг, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 146.153-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;
- (3) 146.67(a)(1A)(i)-ийг;
- (4) 146.67(a)(3)(ii)-ыг;
- (5) 146.67(a)(4A)-г.

(c) Гүйцэд бөглөсөн ИНЕГ маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу ЗББ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас хойш;

- (2) энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу ЗББ-ын гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас өмнө.
- (d) Энэ зүйлийн (с)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:
- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;
 - (2) тухайн байгууллага 146.65-ын дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.
- (e) Дарга, хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол:
- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
 - (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн огноог тогтооно.
- (f) Энэ зүйлийн (е)(2)-ын дагуу огноог тогтоохдоо Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:
- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
 - (2) тухайн байгууллагын төвөгшил;
 - (3) тухайн байгууллагын ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
 - (4) гэрчилгээг сунгах хугацаа;
 - (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
 - (6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.
- (g) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу ЗББ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.
- (h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.

146.153. Зохион бүтээх байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт

- (a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 146.151(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.
- (b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаах ёстой:
- (1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилт болон үйлчлүүлэгчийн хүсэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;
 - (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг болохыг бататгах журам;
 - (3) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг залруулсан болохыг бататгах залруулах арга хэмжээний журам;

- (4) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
 - (5) хүсэлт гаргагчийн байгууллагын аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх зорилгоор аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;
 - (6) энэ Дүрмийн шаардлагыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохиромжтой болон үр дүнтэй байдлыг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам.
- (c) Аюулгүй байдлын бодлогын журам нь аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгож, хэрэгжүүлж, мөрдөж байгааг бататгах ёстой.
- (d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:
- (1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах залруулах арга хэмжээг эргэн хянах;
 - (3) залруулах арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - (4) авсан залруулах арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.
- (e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:
- (1) хүндрэл үүсгэж болох асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн хянах;
 - (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - (4) авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.
- (f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь:
- (1) аудит хийх үйл ажиллагааны шинж чанарыг тооцож, аудит хийх байрлал болон давтамжийг тодорхойлох;
 - (2) аудитыг тухайн үйл ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэггүй, сургалтад хамрагдсан аудитын ажилтан гүйцэтгэдэг болохыг бататгах;
 - (3) аудитын үр дүнг, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгах;
 - (4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаардах;
 - (5) авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн хянах аудит хийдэг болохыг бататгах ёстой.
- (g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь:
- (1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг үндэслэн чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тодорхойлох;

- (2) чанар баталгаажуулалтын тогтолцооны дүгнэлт хийх хариуцлага хүлээсэн менежерийг тодорхойлох;
- (3) тухайн дүгнэлтийн үр дүнг дүгнэж, бүртгэл хийдэг болохыг бататгах ёстой.
- (h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй байна.
- (i) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-ний өдөр хүчингүй болно.

Хавсралт А - Загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн эрх шилжүүлэх

Энэ Хавсралт нь нисэхийн бичиг баримтыг хүчингүй болгох, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл зөрчлийн мэдэгдэл гаргах эрхээс бусад, загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн эрх шилжүүлэхэд шаардагдах мэргэшил, туршлага болон холбогдох эрх, хязгаарлалтыг тогтооно.

А.1. Эрх, хязгаарлалт

(a) Загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн шилжүүлсэн эрх эзэмшигч нь агаарын хөлөг ЗББ-ын зөвшөөрөлтэйгээр 146.51(a)(3)-т заасан удирдах ажилтны үүрэг гүйцэтгэж болно.

(b) Агаарын хөлөг ЗББ нь, хэрэв загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн шилжсэн эрх эзэмшигч 146.51(a)(3)-т заасны дагуу томилогдсон удирдах ажилтан бол зөвхөн тухайн эзэмшигчид шилжсэн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно.

(c) Тухайн эзэмшигч нь энэ Дүрмийн дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг ЗББ-д ажиллахаа больсон даруйд загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэхийг зогсооно.

(d) Тухайн шилжүүлсэн эрх эзэмшигчийн зөвшөөрч болох загварын өөрчлөлтийн хүрээг тодорхойлох зорилгоор загварын өөрчлөлтийг дараах байдлаар ангилна:

- (1) А ангилал-инженерингийн иж бүрэн үндэслэл, үнэлгээ болон нотолгоо шаардсан загварын өөрчлөлт;
- (2) В ангилал-инженерингийн иж бүрэн үндэслэл, үнэлгээ болон нотолгоо шаардахгүй загварын өөрчлөлт.

(e) Дарга, загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн шилжүүлсэн эрх эзэмшигчийн олгосон загварын зөвшөөрлийн хамрах хүрээнд хязгаарлалт болон хориг тогтоож болно.

(f) 146.51(a)(3)-т шаардсан удирдах ажилтан нь зөвхөн дараах нислэгийн зааврын нэмэлт хавсралтыг батална:

- (1) загварын өөрчлөлтийн хэсгийг бүрдүүлж байгаа, түүнээс шууд үүдэлтэй;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт байгаа.

А.2. Мэргэшил

(a) Загварын өөрчлөлтийн зөвшөөрлийн шилжүүлсэн эрх эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг ЗББ-ын ажилтан байна.

(b) ЗББ-ын загварын зөвшөөрлийн эрх олгох удирдах ажилтан нь:

- (1) дараах тодорхой мэдлэг болон ойлголттой байна:
 - (i) тухайн байгууллагын Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан зохион бүтээх ажиллагааны хяналтын тогтолцооны талаар;
 - (ii) энэ Дүрэм болон ИНД-21-ийн зохион бүтээх ажиллагааны холбогдох заалтын талаар;

- (2) тухайн удирдах ажилтны ур чадварыг тодорхойлох зорилгоор Даргын шаардаж болох шалгалт, эсхүл ярилцлагыг өгсөн байна;
- (3) А ангиллын загварын өөрчлөлтийн хувьд:
 - (i) хүлээн зөвшөөрөхүйц инженерингийн бакалавр, эсхүл түүнтэй дүйцэх зэрэгтэй байна;
 - (ii) 8 жилийн туршлагатай, үүний максимум 4 жил нь их сургуулийн инженерингийн сургалт байж болно;
 - (iii) А ангиллын загварын өөрчлөлттэй холбоотой инженерингийн даалгаврыг биелүүлэхтэй холбоотой чадвараа харуулсан Даргын хүлээн зөвшөөрөхүйц хангалттай туршлагатай байна;
- (4) В ангиллын загварын өөрчлөлтийн хувьд:
 - (i) тогтоосноос доогуур мэргэшил болон туршлагыг Дарга хүлээн зөвшөөрч болохоос бусад тохиолдолд, энэ хэсгийн (3)-ын шаардлагыг хангасан байна;
 - (ii) А болон В ангиллын загварын өөрчлөлтийг ялгах чадвараа харуулсан байна.

--oOo--